НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 21 ДҮГЭЭР ХОРООНЫ НУТАГТ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “БОЛОР ОРГИЛ ЮНИОН” ХХК-ИЙН “БЕТОН ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6828493 /



ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН: “БОЛОР ОРГИЛ ЮНИОН” ХХК

УЛААНБААТАР ХОТ 2026 ОН

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 4
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл 4
1.2 Төслийн байршил 5
1.3. Үйлдвэрийн үйл ажиллагаа, хүчин чадал 6
1.4. Түүхий эд, туслах материал 8
1.5. Усан хангамж 9
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ НУТАГ ДЭВСГЭРИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ 10
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ 13
3.1. Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл 16
3.2. Хөрсөн бүрхэвч болон ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл 17
3.3. Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл 18
3.4. Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл 19
3.5. Нөлөөллийн үнэлгээний нэгтгэл, дүгнэлт 19
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 20
4.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт. 20
4.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө 22
4.3 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө 23
4.4 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө 26
4.5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө 26
4.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 27
4.7 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө 28
4.8 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө 29
БҮЛЭГ 5. ХАВСРАЛТ 31

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн мэдээлэл 4
Хүснэгт 2. Үйлдвэрийн хүчин чадал 6
Хүснэгт 3. Үйлдвэрийн бүрэлдэхүүн 7
Хүснэгт 4. Жижиг дүүргэгч материалын хэмжээ 8
Хүснэгт 5. Нийт ашиглах усны хэмжээ 9
Хүснэгт 6. Болзошгүй сөрөг нөлөөллийн магадлан жагсаалт 14
Хүснэгт 7. Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээ 16
Хүснэгт 8. Хөрс, ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээ 17
Хүснэгт 9. Газрын доорх усанд нөлөөлөх байдлын үнэлгээ 18
Хүснэгт 10. Нийгэм, эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээ 19
Хүснэгт 11. Нөлөөллийн үнэлгээний дүгнэлт 20

Хүснэгт 12. БОМТ-ний зардлын задаргаа /мян.төг/.....21
Хүснэгт 13. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....22
Хүснэгт 14. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....23
Хүснэгт 15. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....26
Хүснэгт 16. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....26
Хүснэгт 17. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....27
Хүснэгт 18. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....28
Хүснэгт 19. БОМТ-ий хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө.....29

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг.....5
Зураг 2. Төслийн талбайн фото зураг.....6
Зураг 3. Төслийн талбайн байршил.....6
Зураг 4. Бетон зуурмагийн үйлдвэрийн технологийн дамжлагын бүдүүвч.....7
Зураг 5. Гүний худгийн байршил.....9
Зураг 6. Төслийн талбайн ургамлын зураг.....12
Зураг 7. Төслийн талбайн хөрсний зураг.....13
Зураг 8. Мод тарих заавар.....25

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Хүснэгт 1. Төслийн мэдээлэл

Нэг. Ерөнхий мэдээлэл		
1.1	Төсөл хэрэгжүүлэгч:	"Болор оргил юнион" ХХК
1.2	Төсөл хэрэгжүүлэгчийн улсын бүртгэлийн дугаар	9011836701
1.3	Регистрийн дугаар	6828493
1.4	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 7-р хороо, 15-р хороолол, 37б, 16 тоот
1.5	Газар эзэмших эрхийн гэрчилгээ	Нийслэлийн Засаг даргын 2021.07.06-ний өдрийн А/539 тоот шийдвэрээр 9992 мкв талбай бүхий газрыг 15 жилээр эзэмшдэг. - нэгж талбарын дугаар: 178100719 - улсын бүртгэлийн дугаар: Э-2206005137 - гэрчилгээний дугаар: 0000017306
1.6	Харилцах утас:	+976-99997978, +976-88885890
Хоёр. Төслийн талаарх мэдээлэл		
2.1	Төслийн нэр	"Бетон зуурмагийн үйлдвэр" төсөл
2.2	Төсөл хэрэгжих байршил	Хан-Уул дүүргийн 21-р хорооны нутаг дэвсгэрт хэрэгжүүлдэг.
2.3	Төслийн хүчин чадал	"Болор оргил юнион" ХХК-ийн "Бетон зуурмагийн үйлдвэр" нь 1 цагт 120 $м^3$ бетон зуурмаг зуурах хүчин чадалтай бөгөөд улирлын чанартайгаар 4 сарын 1-нээс 11 сарын 1 хүртэл жилд 170 хоног ажиллаж, 100'000 $м^3$ бетон зуурмаг зуурах хүчин чадалтай юм.
2.5	Усан хангамж	Гүний худаг
2.6	Хог хаягдал	Ахуйн хатуу хог хаягдлыг хогийн цэгт төвлөрүүлэн "Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ-тэй байгуулсан гэрээний дагуу Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2022 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 32/03 дугаар тогтоолоор батлагдсан энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам зэргийг үндэслэн тээвэрлүүлэн зайлуулж байна.
2.7	Зам харилцаа	Улаанбаатар хотод байрлах тул Морингийн зам дагуу, автозамаас үйлдвэрийн талбай хүртэл 100м зайд байрлана.
2.8	Харилцаа холбоо	Skytel, Mobicom, Unitel, G-mobile зэрэг бүх төрлийн үүрэн телефоны сүлжээнд холбогдсон.
2.9	Газарзүйн байршил, координат /UTM 48N/	630465.26 5301129.82 630550.94 5301204.23 630608.81 5301137.78 630523.06 5301063.47

1.2 Төслийн байршил

“Болор оргил юнион” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Бетон зуурмагийн үйлдвэр” төсөл нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 21-р хорооны нутаг дэвсгэрт 0.9 га талбайд газар ашиглаж үйл ажиллагаагаа явуулж байна.



Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг







Зураг 2. Төслийн талбайн фото зураг



Зураг 3. Төслийн талбайн байршил

1.3. Үйлдвэрийн үйл ажиллагаа, хүчин чадал

“Болор оргил юнион” ХХК-ийн “Бетон зуурмагийн үйлдвэр” нь 1 цагт 120 м^3 бетон зуурмаг зуурах хүчин чадалтай бөгөөд улирлын чанартайгаар 4 сарын 1-нээс 11 сарын 1 хүртэл жилд 170 хоног ажиллаж, 100’000 м^3 бетон зуурмаг зуурах хүчин чадалтай юм.


Хүснэгт 2. Үйлдвэрийн хүчин чадал

№	Бетон зуурмагийн марк	Жилд ажиллах хоног	Цагт үйлдвэрлэх хүчин чадал, м^3	Жилд үйлдвэрлэх хүчин чадал, м^3

1	М150-М450	170	120	100000
2	С8/10-С30/37	170	120	100000

Хүснэгт 3. Үйлдвэрийн бүрэлдэхүүн

Алба	Албан тушаал	Орон тоо
ЗХНА	Захирал	1
	Үйлдвэрийн дарга	1
	Харуул хамгаалатын ажил	1
Санхүүгийн алба	Нягтлан бодогч	1
	Хангамжийн нярав	1
Үйлдвэр	Технологич инженер	2
	ХАБЭА-н инженер	1
	Лаборант	3
	Узелийн оператор	2
	Тоног төхөөрөмжийн засварчин	1
	Помпны жолооч	1
	Ковшийн оператор	1
	Помпны туслах	1



Зураг 4. Бетон зуурмагийн үйлдвэрийн технологийн дамжлагын бүдүүвч

1.4. Түүхий эд, туслах материал

Түүхий эд, материал.

Түүхий эд материал авах газрууд:

- Дайрга. Улаанбаатар хот Шувуун фабрикт байрлах "Урал дизель" ХХК-с дайрга татаж авдаг.
- Элс. Улаанбаатар хот шувуун фабрикт байрлах "Хөх шугам " ХХК болон "Өвөр арцат" ХХК -ийн элсний карьераас элсээ татаж авдаг.
- Цемент. "Монцемент бюлдинг материалс" ХХК, "МАК" ХХК-н цементийн үйлдвэрүүдээс шинжилгээний бичигийг үндэслэн худалдан авч хэрэглэдэг.
- Химийн нэмэлт. Улаанбаатар хотын Сонсголонд байрлах "Ди Эф Ар Ти" ХХК - ийн DF төрлийн химийн нэмэлтийг хэрэглэнэ.

Түүхий эд материалын шинж чанар:

Бетон зуурмагийн үндсэн түүхий эдээр том ба жижиг дүүргэгч /элс/, барьцалдуулагч буюу цемент, шаардлага хангасан найрлага бүхий ус хэрэглэнэ.

Том дүүргэгч материал.

MNS 390-1998 (Барилга байгууламжын ажилд хэрэглэх дайрга), MNS 2803:2004 (Хүнд бетонд хэрэглэх дүүргэгч материал) стандартын шаардлагыг хангасан 5-10 мм, 10-20 мм-ийн ширхэглэлтэй дайргыг хэрэглэнэ.

Жижиг дүүргэгч материал.

Элс MNS 0392:2014 (Барилга байгууламжын ажилд хэрэглэх элс), MNS 2803:2004 (Хүнд бетонд хэрэглэх дүүргэгч материал) стандартууд болон энэ стандартын шаардлагыг хангасан байгалийн болон баяжуулсан бүдүүн, дунд зэргийн ширхэглэлтэй элсийг хэрэглэнэ. Бетон зуурмагт хэрэглэх элсний ширхгийн бүрэлдэхүүн нь дараах хүснэгтэд заасан хязгаарт байвал зохино.

Хүснэгт 4. Жижиг дүүргэгч материалын хэмжээ

Шигшүүрийн нүх хэмжээ, мм	Шигшүүр дээрх нийлбэр үлдэц, жингийн хувиар
5	0
2.5	0-20
1.25	15-45
0.63	35-70
0.315	70-90
0.14	90-100
0.14 мм –ийн шигшүүрээр өнгөрөх хэсэг	10-0
Ширхэгийн модуль	2.1-3.25

Барьцалдуулагч материал.

MNS 974-2008 стандартын шаардлага хангасан PC42.5 болон PC52.5 ангийн портланд цементийг барьцалдуулагчаар хэрэглэнэ.

Ус.

Бетон хольцонд MNS 12439-2012 “Бетонд хэрэглэх ус” стандартын шаардлага хангасан ус эсвэл ундны зориулалттай усыг шууд хэрэглэнэ.

1.5. Усан хангамж

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 21-р хороо Морингийн зам гэдэг газарт хэрэгжиж буй “Болор оргил юнион” ХХК-ийн “Бетон зуурмагийн үйлвдэр”-ийн талбай дах гүний худгаас хэрэгцээний усаа хангадаг.

Худгийн солбицол	106°44’42,42” E	47°51’00,37” N

Уг гүний худаг нь 12 м гүнтэй, усны ундарга нь 5 л/с юм.



Зураг 5. Гүний худгийн байршил

Усны тооцоолол.

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралт дах орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны нормын “Хүйтэн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон нийтийн байр”-ын ус хэрэглээний дундаж нормд заасны дагуу 80 л/хоног/хүн гэж үзвэл нийт 17 ажилдчын ус ашиглах тооцоог хийж гүйцэтгэв.

Үйлдвэрийн хэрэглээнд ашиглах усны хэмжээг А/301 дугаар тушаалын 6 дугаар хавсралт “Барилгын салбарын усны норм”-ын бетон зуурмагийн үйлдвэр шууд системтэй 0.3 $м^3$/цаг гэсэн нормын дагуу тооцоолсон.

Ногоон байгууламжийн усалгаа: /2017 оны Байгаль орчин аялал жуулчлалын яам, Мод тарих гарын авлага/ Нийт талбайн 20%-д буюу 2000 $м^2$ талбайд 120 ш мод тарихаар тооцвол:

- 1 ширхэг модыг 40 л усаар усална,

Хүснэгт 5. Нийт ашиглах усны хэмжээ

	Нормын хэмжээ, л	Хүчин чадал	Усны хэрэглээ, $м^3$ хоног	Жилд ажиллах хоног/тоо	Усны хэрэглээ, $м^3$ жилд

Ахуйн хэрэглээний усны тооцоо	80 л/хоног/хүн	17	1.36 $м^3$/хон	150	204 $м^3$/жил
Ногоон байгууламжид зарцуулагдах усны хэмжээ	40 л	120 ш	4.80 $м^3$/хон	Жилд 16 удаа усалгаа	76.80 $м^3$/жил
Үйлдвэрийн хэрэглээний усны хэмжээ	0.3 $м^3$/цаг	120 $м^3$	36 $м^3$/хон	170	6120 $м^3$/жил

Худгийн усны хүрэлцээ:

- Худгийн усны ундарга: 5 л/сек
- Усны боломжит нөөц: 432 $м^3$/хоног
- Хоногт хэрэглэх усны хэмжээ: **42.16 $м^3$/хоног**
- Төслийн үйл ажиллагаанд гүний худгийн усны боломжит нөөц хүрэлцээтэй.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ НУТАГ ДЭВСГЭРИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

Уур амьсгал.

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 21-р хорооны нутаг дэвсгэрт байрлах "Болор оргил юнион" ХХК-ийн төслийн талбайн байгаль орчны судалгааны тайлангийн хувьд уур амьсгалын суурь үнэлгээг өгөхдөө Улаанбаатар хот орчмын үндсэн нөхцөл байдлыг суурь болгон авч үзэв.

Агаарын дундаж температур.

Улаанбаатар хотын уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Өөрөөр хэлбэл сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай. Цасан бүрхэвч XI сарын 10-ны үед тогтож III сарын хорьд хүртэл 130 орчим хоног 18 орчим см зузаан цастай байна. Ууландаа цасны зузаан их, цасан шуургатай өдөр 10 орчим байдаг ажээ. Жилийн хамгийн богино өдөр-өвлийн туйлын өдөр XII сарын 22-нд болох бөгөөд энэ өдөр өдрийн урт 8 цаг 24 минут үргэлжилнэ.

Хур тунадас.

Улаанбаатарт жилд дунджаар 233 мм тунадас унаж ууршилт нь 648 мм болдог. Чийглэгийн байдал 0.36 байдаг. Богдхан, Чингэлтэй зэрэг уулуудад тунадас арай их буудаг. Богдхан уулан дах Хүрэлтогоотын одон орны орчимд 659 мм тунадас унасан нь Улаанбаатарын төдийгүй манай улсын хэмжээнд цаг уурын станцад тэмдэглэгдсэн хамгийн их тунадас болсон юм. Улаанбаатарт агаарын харьцангуй чийг 1-р сард 70 орчим хувь, 7-р сард 60 орчим хувь байдаг.

Агаарын даралт ба салхины горим.

Улаанбаатар хот тус орны салхи багатай газрын тоонд орно. Жилдээ салхигүй өдөр 100 орчим байх бөгөөд салхины хурд 4-6 м/с, баруун хойд зүгийн салхи голлоно. Салхины хамгийн их хурд нь 40 м/с хүрч байжээ. Өвөл салхи багатай, хавар салхи ихтэй.

Улаанбаатарт хүйтрэлтгүй үргэлжлэх хугацаа V сарын 29-ны орчмоос IX сарын 1 орчим хүртэл буюу 90 гаруй хоног байна. Өөрөөр хэлбэл энэ хугацаанд агаарын температур 0°-аас доош буухгүй гэсэн үг. Жил жилийн онцлогоос болоод энэ хоногийн тоо арай олон, цөөн байж болох нь тодорхой Жилийн хамгийн дулаан сар нь 7-р сар, дундаж дулаан нь 17°C бөгөөд хамгийн их халуун болсон нь 38.6°C хүрсэн. Ган болох магадлал 30 орчим хувь зуны туйл буюу жилийн хамгийн урт өдөр Улаанбаатар VI сарын 22-нд болж өдөр 16 цаг 02 минут үргэлжилнэ. Энэ өдөр үдийн нарны мандалтын тусгалын өнцөг 65.5° болно. Монгол орны уур амьсгалын мужлалын хувьд авч үзвэл Улаанбаатар хот нь хуурайдуу сэрүүн зунтай хахир өвөлтэй нутагт багтана. Газрын гадарга орчмын салхины горим тухайн орон нутгийн уул зүйн онцлог, агаар мандлын ерөнхий орчил урсгал, дэвсгэр гадаргын хотгор гүдгэр зэргээс хамаарна. Улаанбаатар хот тус орны салхи багатай газрын тоонд орно. Жилдээ салхигүй өдөр 100 орчим байх бөгөөд салхины хурд 4-6 м/с, баруун хойд зүгийн салхи зонхилно. Салхины хамгийн их хурд нь 40 м/с хүрч байсан.

Төсөл хэрэгжих талбайн ургамлан нөмрөгийн хэв шинж.

Улаанбаатар хот нь Хэнтийн уулын тайгын тойрог, Монгол дагуурын уулын ойт хээрийн тойрог гэсэн хоёр тойргийн уулзвар нутагт хамаарна. Хотгор гүдгэрийн мужлалаар Улаанбаатар хотыг тойрон хүрээлэх Хэнтийн нурууны баруун захын салбар дундаж, нам уулс, тэдгээрийг тусгаарлан орших голуудын хөндийгөөс бүрдэнэ. Эдгээр уулс нь Сибирийн геоморфологийн их мужийн Хэнтийн мужид багтах хавтгайдуу оройтой, эрс хажуу бүхий дундаж уулсын системд хамаардаг.

Туул голын дагуу голын эргийн дагуу ледебурын бургас зонхилж, 1 зүйлийн бургас, лавронавчит улиас, монос, өрөл, долоогоно, улаалзгана зэрэг жимст бут цөөнгүй ургадаг. Хотын ногоон бүсэд голын дагуу 4443 га талбай буюу 75.2 мян.шоо метр нөөцтэй бургасан шугуй, 549 га талбай буюу 41.0 мянган шоо метр нөөцтэй улиасан шугуй сийрэг тархана. Нийслэл хотын нутаг дэвсгэрт хээрийг бүрдүүлэх ургамалд крыловын хялгана, саман ерхөг, дэрвээн хазаар өвс, том цэцэгт дааган сүүл, сунагар биелэг өвс, агь, ишгэн шарилж, адамсын шарилж, ишгүй гичгэнэ, имт гичгэнэ, дагуур хатны өвс, арзгар согоот, алаг башир, одой далан түрүү, цэх түмэн тана, дагуур ганга зэрэг ургамлууд зонхилон ургадаг.

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн ургамалжилт нь Евразийн хээрийн мужийн Монгол-Дагуурын хээрийн провинцийн Баруун Хэнтий уулын тойрогт хамрагддаг ба газрын гадаргаас хамаарч өндөр уул, ойт хээр, уулын нугархаг хээрийн болон тал хөндийн ургамалжилтаар ялгагдана.

“Бетон зуурмагийн үйлдвэр”-ийн талбай нь ургамлын төрлөөр “Суурин газар” ангилалд багтаж байгаа бөгөөд нийт ургамлан бүрхэц 70-75 хувь, сайрын хялгана, шарилж зэрэг зонхилон ургана.



Зураг 6. Төслийн талбайн ургамлын зураг

Хөрсөн бүрхэвч.

Судалгааны талбай нь Монгол орны хөрс–газарзүйн мужлалын хувьд Хангайн их мужийн Өндрийн бүсшилтэй нутгийн Хэнтийн мужийн Хэнтийн захын тойрогт хамаарагдана. Монгол оронд тархсан бүх хөрсийг уулын ба тал хөндийн гэсэн 2 том бүлэгт ялгах ба бүлэг тус бүрийн дотор хөрсний хэв шинжүүдийг өндрийн ба өргөргийн бүсүүдийн дарааллаар жагсааж, хөрсний хэв шинжийг цааш нь ямар хэв шинж, төрлүүдэд хуваах үндэслэлтэйг үзүүлсэн байдаг.



Зураг 7. Төслийн талбайн хөрсний зураг

Дээрх зургаас харахад төслийн талбай нь Аллювийн нугын сулавтар хөгжилтэй хөрстэй орчинд хамаарагдаж байна.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Болор оргил юнион” ХХК-ийн “Ноос ноолуур боловсруулж, сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоохдоо судалгааны материалуудыг үндэслэн магадлан жагсаах аргаар тодорхойлсон болно. Энэ арга нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн төрлийг жагсаан тэдгээрийг төсөлтэй холбоотойгоор харьцуулан тодорхойлсон хүснэгт бүрдүүлэх арга юм.

Аливаа төслийг хэрэгжүүлэх үеийн үйл ажиллагаа нь тухайн орон нутгийн байгаль орчны төлөв байдал болон нийгэм, эдийн засагт хэрхэн нөлөөлөх, нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодорхойлохын тулд магадлан жагсаах буюу хяналтын хуудасны аргыг өргөн хэрэглэдэг. Энэ аргаар тухайн төслийн болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг хийхдээ экспертүүдийн гаргасан үнэлэлт, дүгнэлтүүдийг магадлалын онолд тулгуурлан боловсруулах замаар гүйцэтгэв. Тус аргыг ашиглах үед экспертүүдийн гаргасан үнэлэлт, дүгнэлт оролтын мэдээ болох бөгөөд үр дүнд төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулах нөлөөллийг тогтооно. Болзошгүй нөлөөлөлд хамрагдах байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт, байгалийн нөөц ашиглалт, хүрээлэн буй орчны өөрчлөлт, нийгэм-эдийн засаг, бусад гэсэн 5 үндсэн бүлэгт багцлан хуваах, магадлан жагсаах аргаар судлав.

Хүснэгт 6. Болзошгүй сөрөг нөлөөллийн магадлан жагсаалт

№	Байгаль орчны үзүүлэлт	Хэлбэр			Хугацаа				Эрчим		
		Нөлөөлөлтэй эсэх, +,-, 0	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт											
1	Газрын доорх урсацын өөрчлөлт	0									
2	Газрын доорх усны чанарт өөрчлөлт	-		-		-					-
3	Гадаргын усны өөрчлөлт	0									
4	Агаарын чанарын өөрчлөлт	-	-			-				-	
5	Ургамлын бүтцийн өөрчлөлт	-	-			-					-
6	Хөрсний элэгдэл, эвдрэл	-	-				-			-	
7	Геологийн тогтцын өөрчлөлт	0									
8	Зэрлэг амьтдын орон зай	0									
9	Уур амьсгалын бичил өөрчлөлт	0									
2. Байгалийн нөөц ашиглалт											
10	Гадаргын нөөц баялаг	-				-					-
11	Бэлчээрийн байдал	0									
12	Эрдэс түүхий эдийн нөөц	0									
13	Эрчим хүчний нөөц	-				-					-
3. Байгаль орчны өөрчлөлт											
14	Ундны усны чанар, хэмжээ	0									
15	Урсгал усны хэрэгцээ	0									
16	Агаарын бохирдол	-	-			-				-	
17	Хөрсний эвдрэл бохирдол	-	-				-				-
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор											
18	Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	0									
19	Ландшафтийн хэлбэр, өнгө өөрчлөгдөх	0									
20	Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	0									
21	Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	0									
22	Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх	0									
5. Эдийн засаг, нийгмийн асуудал											
23	Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	+	+			+				+	
24	Орон нутгийн орлого нэмэгдэх	+	+			+				+	
25	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+	+				+			+	
26	Ажлын байр нэмэгдэх	+	+				+			+	
27	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+	+				+			+	
28	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	-		-						-	
Бусад нөлөөлөл											

29	Хүн амын дунд халдварт өвчин тархах	-		-		-					-
30	Малын халдварт өвчин тархах	0									
31	Байгалийн онц аюултай үзэгдэл /үер, шороон шуурга, цасан шуурга, аянга/	0									
Нөлөөлөлгүй		16									
Сөрөг нөлөөтэй		-10	-7	-3	-1	-7	-2			-4	-6
Эерэг нөлөөтэй		+5	+5			+2	+5		+1	+4	

Энэхүү хүснэгтэд төсөл хэрэгжих үе шат, байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх нөлөөллийн хэлбэр, хугацаа, эрчимшил-ийг магадлан жагсаан харуулсан болно. “+” нь эерэг нөлөөлөл, “-” нь сөрөг нөлөөлөл, “0” нь нөлөөлөлгүйг илэрхийлнэ.

- **Шууд нөлөөлөл:** Болзошгүй нөлөөллийн ихэнх нь хамрагдах бөгөөд үүний улмаас төсөл хэрэгжих орчны байгалийн унаган төрх алдагдах, ялангуяа хөрс эвдрэх, хөрсний ус бохирдох, ургамлын нөмрөг сүйдэх, хатуу хог хаягдал цуглуулах савыг ил задгай байлгах, эдгээрийг тогтмол зайлуулахгүй байх болон шингэн хаягдлын шугам хоолойны системд гэмтэл гарах зэргээс үүдэн бохирдол үүсэх зэрэг хамрагдана.
- **Богино хугацааны нөлөөлөл:** Авто тээврийн хэрэгслийн тоосжилт, хорт хий, газрын тосны бүтээгдэхүүний ууршилтаас агаарын бохирдол бий болох зэрэг хамрагдаж байна.
- **Урт хугацааны нөлөөлөл:** Төслийн бүтээн байгуулалт, барилга байгууламжийн ажил болон үйл ажиллагаатай холбоотойгоор хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдол, хөрс, усны бохирдол, түймэр зэрэг багтах бөгөөд эдгээр нь эргэж сэргээгдэхдээ удаан хугацаа шаардана.
- **Буцаж нөлөөлөх нөлөөлөл:** Ахуйн хог хаягдалд зохих ариутгал хийгээгүй, хугацаанд нь зайлуулаагүй зэрэг тохиолдлоос шалтгаалж элдэв төрлийн халдварт өвчин гарч болзошгүй тул ариутгал цэвэрлэгээг энэ орчинд тухай бүрд нь хийж байх.
- **Буцалтгүй нөлөөлөл:** Байгаль орчинтой холбоотой бүхий л үйл ажиллагааг хамруулан авч үзэж буй тул авто тээврийн дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хийнээс агаарын бохирдол бий болохоос бусад нь хамрагдаж байна.
- **Өөрөө зохицуулагдах нөлөөлөл:** Авто тээврийн хэрэгслийн дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хийнээс агаарын бохирдол бий болох болзошгүй нөлөөллийг авч үзсэн бөгөөд, энэ нь нэгд үргэлжлэх хугацаа богино, зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй авто тээврийн хэрэгслийн дотоод шаталтаас гарах хорт хий болон авто тээврийн хэрэгслийн бензин шатахууны угаар хамрагдана.
- **Хүчтэй нөлөөлөл:** Байгалийн гэнэтийн болзошгүй осолд тооцогддог нөлөөллүүд болох газар хөдлөл, хүчтэй салхи шуурга, анхаарал болгоомжгүйн улмаас гарах түймэр, тэсрэлт дэлбэрэлт орох бөгөөд энэхүү нөлөөлөлд нэрвэгдсэн байгаль орчин нь нөхөн сэргээгдэхдээ удаан хугацаа шаардана.
- **Дунд зэргийн нөлөөлөл:** Хөрс, хөрсний усанд бохирдуулагч бодис нэвчих, хүн ам, авто тээврийн хэрэгслийн тоо ихэссэнээс ургамал нөмрөг талхлагдах, хог хаягдлыг ариутгах, зөөж тээвэрлэх ажил удаашрах зэрэг зүйлүүд орно.
- **Бага нөлөөлөл:** Төслийн үед ашиглах байгалийн нөөц, эрчим хүч, гадаргын болон газрын доорх усны хэрэглээ зэрэг багтаж байна.

3.1. Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл

Хан-Уул дүүргийн 21-р хорооны нутаг дэвсгэрт хэрэгжих бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагаа нь үйлдвэрлэлийн технологийн онцлогоос шалтгаалан орчны агаарт тодорхой хэмжээний нөлөөлөл үзүүлэх боломжтой. Үйлдвэрийн үндсэн түүхий эд болох цемент, элс, хайрга, дайрга зэрэг материалыг хадгалах, тээвэрлэх, тун хэмжээгээр жинлэн холих зэрэг шат дамжлага бүрт агаарт тоосонцор болон зарим төрлийн бохирдуулагч бодис ялгарах нөхцөл бүрдэнэ.

Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад агаарт нөлөөлөх гол эх үүсвэр нь цементийн силос, дүүргэгч материалын агуулах, дамжуулагч болон бетон холигч төхөөрөмжийн ажиллагаатай холбоотойгоор үүсэх тоосжилт юм. Цемент нь маш нарийн ширхэгтэй нунтаг бүтэцтэй тул силост хадгалах, ачиж буулгах, холигч руу дамжуулах үед нарийн ширхэгтэй цементэн тоос агаарт дэгдэх эрсдэлтэй. Мөн элс, дайрга, хайрга зэрэг дүүргэгч материалыг ачиж буулгах, конвейроор дамжуулах, агуулах талбайд хадгалах үед салхи болон механик хөдөлгөөний нөлөөгөөр тоосонцор үүсэх боломжтой.

Үйлдвэрийн талбайд бетон зуурмаг үйлдвэрлэх үйл явцын үед бетон холигч төхөөрөмжөөс тодорхой хэмжээний тоос ялгарч болзошгүй бөгөөд энэ нь ихэвчлэн богино хугацааны, үйлдвэрийн талбай орчимд төвлөрсөн нөлөөлөл байдаг. Үүнээс гадна үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглагдах ачааны автомашин, бетон тээврийн миксер машинуудын хөдөлгөөн, үйл ажиллагаанаас үүдэн шатахуун шаталтын бүтээгдэхүүн болох нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), азотын исэл (NOx), хүхрийн давхар исэл (SO_2), нүүрсхүчлийн хий (CO_2) зэрэг хийн бохирдуулагч агаарт ялгарах боломжтой. Мөн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс замын гадаргуу дээр хуримтлагдсан нарийн ширхэгт тоос агаарт дэгдэх нөхцөл үүсдэг.

Ил задгай талбайд хадгалагдах элс, дайрга зэрэг материалууд нь хуурай болон салхитай үед салхины нөлөөгөөр тоос үүсгэж болзошгүй бөгөөд энэ нь орчны агаарт түр хугацааны тоосжилт үүсгэх шалтгаан болдог. Ялангуяа хуурай улиралд материалын овоолго болон үйлдвэрийн дотоод зам талбайгаас тоосжилт нэмэгдэх магадлалтай.

Гэвч бетон зуурмагийн үйлдвэрт цемент силосын шүүлтүүрийн төхөөрөмж, хаалттай дамжуулах систем, ус шүрших болон талбайн тоос дарах арга хэмжээ зэргийг хэрэгжүүлснээр тоосжилтыг мэдэгдэхүйц бууруулах боломжтой. Мөн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохион байгуулалттай байлгах, дотоод зам талбайг тогтмол услах, материалыг зөв хадгалах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлснээр агаарт үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгаж болно.

Хүснэгт 7. Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээ

Нөлөөллийн хэлбэр	**Бохирдлын эх үүсвэр**	**Нөлөөллийн онооны үзүүлэлт**								**Нөлөөллийн түвшин**
		H	A_1	A_2	A_3	B_1	B_2	C	Нийт	
Түүхий эдийн буулгалт	Төслийн үед ашиглах түүхий эдийн буулгалт, ачилт, хадгалалтаас үүдэн агаарт тоосжилт үүснэ	-1	2	2	2	1	2	1	-10	Дунд
Тоосжилт, шаталтын хий	Барилгын үе болон тээвэрлэлтийн үеэс гарах автомашины тоосжилт, хорт хий	-1	1	2	3	1	1	2	-10	Дунд

Үнэр, хог хаягдал	Төслийн талбай дах хог хаягдлыг тогтсон хугацаанд зайлуулаагүй, ариутгаагүйгээс үүдэн агаарт үнэрийн бохирдол үүсч болзошгүй	-1	1	1	2	1	1	1	-7	Бага
Дүгнэлт										**Дунд**

3.2.Хөрсөн бүрхэвч болон ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл

Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл:

Ашиглалтын үе шатанд үйлдвэрийн үйл ажиллагаа, тээвэрлэлтийн давтамжтай хөдөлгөөнөөс шалтгаалан хөрсний гадаргын **механик элэгдэл**, **нягтшил нэмэгдэх**, **тоосжилт үүсэх** эрсдэл бий. Түүнчлэн түлш, тос, техникийн шингэний санамсаргүй асгаралт нь хөрсөнд шингэх тохиолдолд **хөрсний химийн найрлагад сөрөг өөрчлөлт** оруулах боломжтой.

Гэвч төслийн хүрээнд байгальд шууд хортой химийн бодис ашиглахгүй, хаягдал бодис хөрсөнд шингэх нөхцөл бүрдэхгүй тул **хөрсний химийн бохирдол үүсэх магадлал бага** гэж үнэлэгдэнэ. Зохих дэглэм, хяналт хэрэгжүүлсэн нөхцөлд хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл **хянагдах боломжтой** байна.

Ургамалд үзүүлэх нөлөөлөл:

Ашиглалтын үеийн тоосжилт нь ургамлын навчны гадаргууг бүрхэж, амьсгал болон фотосинтезийн үйл явцыг түр хугацаанд сааруулах нөлөө үзүүлнэ. Мөн ургамлын үндэс орчмын хөрсний нягтшил нэмэгдэх нь шим тэжээлийн шингээлтэд сөргөөр нөлөөлөх магадлалтай.

Нөгөө талаас төслийн хүрээнд хэрэгжүүлэх ногоон байгууламж, зүлэгжүүлэлт, нөхөн сэргээлтийн ажлууд нь ашиглалтын үе шатанд ургамлын бүрхэвчийг нэмэгдүүлж, хөрс хамгаалах, бичил орчны нөхцөлийг сайжруулах эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

Хүснэгт 8. Хөрс, ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээ

Нөлөөллийн хэлбэр	**Нөлөөлөл**	**Нөлөөллийн онооны үзүүлэлт**								**Нөлөөллийн түвшин**
		Н	A_1	A_2	A_3	B_1	B_2	С	Нийт	
Хөрс, ургамал эвдрэлд орох, бохирдох	Түүхий эдийн буулгалтаас үүдэн хөрсний шинж чанар өөрчлөгдөх	-1	1	1	3	1	2	1	-9	Бага
	Хог хаягдлыг төслийн талбайд удаан хуримтлуулснаас үүдэн хөрс бохирдох	-1	2	3	1	1	2	2	-11	Дунд
	Барилга материал, тээвэрлэлтийн үед автомашинаас үзүүлэх нөлөөлөл буюу шатах тослох материалын	-1	2	3	3	1	2	2	-13	Дунд

	алдагдал, төлөвлөлтгүй зам үүсгэх									
Дүгнэлт										**Дүнд**

3.3. Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл

“Болор оргил юнион” ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэр байгуулах төслийн хүрээнд гадаргын усны сүлжээгүй бөгөөд тус дэд бүлэгт газрын доорх усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээ хийгдэх болно.

Төслийн байршил нь Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутагт байрлах бөгөөд тухайн бүс нутаг нь газрын доорх усны сав газрын ангиллаар Туул голын сав газарт харьяалагддаг бөгөөд ундаргын хувьд жилд 5-10 мм/жил/км^2 нөхөн сэргээгдэх талбайд хамаарагдана.

Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээ:

Тус бүлэгт төсөл хэрэгжих явцад гүний усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг үнэлэх ба тус болзошгүй гэж үзсэн сөрөг нөлөөллийн хэлбэрийг дараах байдлаар дүгнэн жагсаав.

1. Үйлдвэрийн усан хангамж болон ахуйн хэрэглээний уснаас өөр зориулалтаар ус ашиглаж боломжит ус ашиглах байдлаас давуулан ашиглах
2. Төслийн талбайд одоогоор гүний худаг өрөмдлөг хийгдээгүй ба худаг өрөмдөх үеийн болгоомжгүй үйл ажиллагаанаас гүний усанд машин техникийн шатах тосний материал болон бусад бохирдуулах бодис орох
3. Тухайн бүс нутагт үйл ажиллагааг тус “Бетон зуурмагийн үйлдвэр” нь үйл ажиллагаа явуулснаар гүний усыг тодорхой хэмжээнд ашиглах бөгөөд усны нөөцөд үйлдвэрлэлд хэдий хэр ус ашиглаж байна, төдий чинээгээр нөлөө үзүүлэх магадлалтай байна гэсэн үндсэн 3 сөрөг нөлөөлөл бий болж байгаа юм.
4. Мөн ахуйн хэрэглээнээс гарсан хаягдал усыг задгай, цементлэж хамгаалаагүй, энгийн нүхэн жорлон, муу усны нүхийг ашигласнаар тухайн бохир ус, хаягдал нь доош нэвчиж гүний усыг бохирдуулах магадлалтай гэж үзэж байна.

Хүснэгт 9. Газрын доорх усанд нөлөөлөх байдлын үнэлгээ

Нөлөөллийн хэлбэр	**Нөлөөлөл**	**Нөлөөллийн онооны үзүүлэлт**								**Нөлөөллийн түвшин**
		H	A_1	A_2	A_3	B_1	B_2	C	Нийт	
Гадаргын усны нөөц, чанар	Гадаргын усны урсац, чанар нөөцөд нөлөөлөх	0	1	1	2	1	1	1	0	Бага
Газрын доорх усны нөөц баялаг	Төслийн талбай дах гүний худгаас унд ахуйн усны хэрэгцээг ханган ажиллана	-1	2	2	2	2	2	2	-12	Дунд
Усны чанарт	Үйл ажиллагааны явцад санамсаргүй байдлаар шатах тослох материал, шатахуун алдагдсанаар	-1	3	3	2	2	1	2	-13	Дунд

	усны чанарт нөлөө үзүүлнэ									
Хог хаягдал	Төслийн талбай дах ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг ачуулаагүйгээс үүдэн нөлөө үүснэ	-1	1	2	2	1	1	1	-8	Бага
Дүгнэлт										**Дунд**

3.4. Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Төсөл хэрэгжүүлэгчдийн зүгээс ажилчдыг тухайн орон нутаг буюу Хан-Уул дүүргийн 21-р хорооны иргэдээс хангахаар төлөвлөх нь харъяалагдах засаг захиргааны нэгжийн ажилгүйчүүдийн тоог бууруулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, холбогдох татваруудыг төлөх замаар эдийн засаг шууд болон шууд бус замаар нөлөөнө. Төслийн явцад тоос болон дуу чимээний нөлөөлөл нь ойролцоо иргэдэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй. Төслийн байгууламжийн ойр зорчих тээврийн хэрэгслийн тоо нэмэгдсэнээр зам тээврийн осол үүсгэхэд нөлөөлж болзошгүй.

Хүснэгт 10. Нийгэм, эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээ

Нөлөөллийн хэлбэр	**Нөлөөллийн онооны үзүүлэлт**								**Нөлөөллийн түвшин**
	Н	$А_1$	$А_2$	$А_3$	$В_1$	$В_2$	С	Нийт	
Төслийн хэрэгжилтийн үед орлогын албан татвар, нийгмийн даатгал болон эрүүл шимтгэл, мэндийн даатгалын машин авто болон өөрөө явагч механизмын албан татвар, эдэлбэр газар ашигласны төлбөр болон бусад татвар төлбөрийг Монгол мөрдөгдөж буй улсад хууль тогтоомжийн дагуу тооцоолон татвар хэлбэрээр улс орны төсөвт хуримтлуулах замаар эдийн засгийн хөгжилд түлхэц үзүүлэх	+1	1	1	2	3	3	1	+11	Дунд
Ажилчдыг мэргэжлийн сургалтад хамруулах, ажлын байраар хангах замаар амьжиргааны түвшин, нийгэм-эдийн засгийн салбарт дэмжлэг үзүүлэх	+1	1	3	3	1	3	1	+15	Дунд
Дүгнэлт									**Дунд**

3.5. Нөлөөллийн үнэлгээний нэгтгэл, дүгнэлт

"Болор оргил юнион" ХХК-ийн Хан-Уул дүүргийн 21-р хорооны нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх "Бетон зуурмагийн үйлдвэр" төслөөс байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт болох

агаарын чанар, усан орчин, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, нөлөөллийн эрчим, цар хүрээг суурь судалгаа болон хээрийн судалгааны хэмжилтийн мэдээ, лабораторийн дээж шинжилгээнд үндэслэн тодорхойлсныг доор хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 11. Нөлөөллийн үнэлгээний дүгнэлт

Нөлөөлөл	**Нөлөөллийн эрчим цар хүрээ**					
	Эерэг			Сөрөг		
	Бага	Дунд	Их	Бага	Дунд	Их
Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл	-	-	-	1	2	-
Хөрсөн бүрхэвч болон ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл	-	-	-	1	2	-
Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл	-	-	-	2	2	-
Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	-	2	-	-	-	-
Нийт	0	2	0	4	6	0
Дүгнэлт	Нийт үнэлгээний 50% нь дунд зэрэг сөрөг, 33.3% нь бага зэргийн сөрөг, 16,6% нь дунд зэргийн эерэг нөлөөтэй гэсэн ангилалд хамрагдаж байгааг үндэслэн уг төслөөс байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг "**ДУНД**" гэж үнэлж байна.					

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт.

Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд Хан-Уул дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах "Ноос ноолуур боловсруулж, сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх" төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн бөгөөд төсөл хэрэгжүүлэгч төслийн хэрэгжүүлэх нийт хугацаанд энэхүү үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй.

Төслийн 2026 оны БОМТ-г боловсруулахдаа Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 3 дугаар хавсралтын аялал

жуулчлалын төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулгын хүрээнд боловсруулав. Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө, осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө, БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид болон оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө тусгагдсан бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэхэд нийт **12,760.0 мян.төг** зарцуулахаар төлөвлөв.

Төслийн талбайд түүх, соёлын үл хөдлөх дурсгал, археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй тул тусгайлсан зардал төлөвлөөгүй. Гэхдээ төслийн үйл ажиллагааны явцад санамсаргүй байдлаар түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор илэрсэн тохиолдолд тухайн хэсгийн ажлыг нэн даруй зогсоож, холбогдох мэргэжлийн байгууллага болон эрх бүхий байгууллагад мэдэгдэн, хууль тогтоомжийн дагуу хамгаалалтын арга хэмжээ авч ажиллана.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын хураангуйг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 12. БОМТ-ний зардлын задаргаа /мян.төг/

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө	**2,400.0**
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	**5,000.0**
3	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	**1,950.0**
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	**2,260.0**
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	**1,150.0**
7	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	**Дотоод төлөвлөлт болон урсгал зардлаар**
8	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	
	ЖИЛИЙН ЗАРДАЛ	**12,760.0**

4.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 13. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Зардал /мян.төг/	Нийт зардал (5-жилээр) /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Ажилчдын эрүүл мэнд ажлын байрны агааржуулалт, цэвэршүүлэлт	Төслийн талбайд	Дотоод төлөвлөлтөөр		Өдөр бүр	- Агаарын тухай хууль, - MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2023, - Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага - MNS ISO 226:2003 дуу чимээ – хэвийн норм- түвшний хэмжээ
	Түүхий эд буюу элс, дайрга, цементийг битүүмжлэлтэй, салхинаас хамгаалсан хашлага бүхий талбайд хадгалах	Төслийн тадбайд	Дотоод төлөвлөлтөөр		2026 оны 10 сард	
	Төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй машин механизмыг тогтмол онишлогоо үзлэгт хамруулах, засвар үйлчилгээг тухай бүрт хийж гүйцэтгэх	Төслийн үеийн автомашинд	200.0		2026 онд, тогтмол хугацаанд	
	Төслийн үеийн автомашинуудыг тогтмол замаар тээвэрлэлт хийлгүүлэх 10-20 км/цаг хурдыг баримтлах	Төслийн талбай хүртэлх зам талбайд	Мөнгөн хөрөнгө шаардагдахгүй		Өдөр бүр	
Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тээврийн хэрэгслийг тогтсон маршрут, заасан км/цагийн хурдтай зорчуулах	Төслийн талбай орчимд	Мөнгөн хөрөнгө шаардагдахгүй		Өдөр бүр	
	Хөрсний бохирдол, механик эвдрэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй бүх төрлийн түлш, тос тосолгооны материал, химийн бодисыг ус үл нэвтрэх,	Төслийн талбайд	Дотоод төлөвлөлтөөр		Өдөр бүр	

	асгаралт барих дэвсгэр бүхий тусгай зориулалтын талбайд хадгалж, хадгалалтын горимыг мөрдүүлнэ					
Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга зам	Технологийн усыг эргэн ашиглах технологи: Үйлдвэрлэлийн угаалгын болон технологийн усыг 2–3 шатлалт тунадасжуулж, 5–10 м³ багтаамжтай усан санд хуримтлуулан дахин ашиглах систем	Төслийн талбайд	тунадас баригч + усан сан (2 сая)		2026 оны 10 сард	
	Усан хангамжийн шугамд алдагдлын шалгалт улирал тутам хийх	Төслийн талбайд	50.0	200.0	2026 он /Улиарл бүр/	
Нийт			**2,400.0**			

4.3 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Хүснэгт 14. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хугацаа	Баримтлах эрх зүй
Суурь нөхөн сэргээлт	- Талбай тэгшилгээ - 1000 ширхэг мод тарих - Олон наст өвс суулгах	Төслийн талбай, дийцүүлэн хамгаалах талбай	5000.0		2026	Хөрс хамгаалах тухай хууль, Ургамал хамгаалах тухай хууль, MNS 5917-2008, MNS 5918-2023
Нийт				**5,000.0**		

Нэг ширхэг улиас ургалтын хугацаандаа 28 кг тоос шороог өөртөө шингээдэг. Тийм учраас 2-оос дээш настай улиасыг тоосжилтын их үүсвэрийн орчимд улиас салхины дээд талаар хашааны дагуу 40-60 см гүн, 50 см өргөнтэй нүх ухаж тарина. Тарих зөвлөмжийг 6-р бүлэгт тусгасан. Хашааны баруун талаар ногоон байгууламжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Ногоон байгууламж байгуулахад хийгдэх арготехникийн ажиллагаа

Зүлэг тарих зөвлөмж

1. Талбайгаа зүлэгжүүлэхийн өмнө шим тэжээл муутай газрын хөрсийг 20-30 сантиметр гүн хагалж хайрга чулууг цэвэрлэж аваад үлдсэн шороог зөөсний дараа хүрэн хөрсийг 2.5х2.5 сантиметрийн гишгүүрээр гишгэж, ургамлын үндэс болон бусад хогноос цэвэрлэж, гишгэсэн хар хүрэн хөрсийг 20 сантиметрээс доошгүй зузаан дэвсэж гадаргууд жигд тарааж тэгшилснээр зүлэг тарих талбай бэлэн болно.
2. Үрийг нэг метр квадрат талбайд 50-80 грамм орохоор тооцоолж салхи багатай тогтуун өдөр талбайд жигд цацаад тармууруар самнасны дараа элсээр нэгээс хоёр сантиметр зузаан хучин.
3. Үүний дараа 50-100 килограмм жинтэй булаар булдаж зөөлөн шүршиж усална.
4. Зүлэгжүүлэх ажлыг тавдугаар сарын хоёрдугаар хагасаас 7 сарын 10-нд багтааж тарьдаг байна.


Тарьсан үрээ соёолтол хөрсийг нь чийгтэй байлгахын тулд өдөр бүр өглөө оройн сэрүүнд нэг метр квадрат талбайд 30-40 литр ус, үр соёолсноос хойш нэг метр квадрат талбайд 20-30 литр ус орохоор бодож долоо хоногт гурваас дөрвөн удаа услах бөгөөд гандуу үед өдөр бүр услах хэрэгтэй.

Мод, сөөг тарих зөвлөмж

Нүх ухах: Мод, сөөгийг ургуулахад гол анхаарах зүйл бол суулгах нүхийг зөв ухаж бэлтгэх явдал юм. Навчит мод суулгах нүхийг 0.7-1.0 м-ийн диаметртэй, 0.6 м хүртэл гүн ухаж бэлтгэнэ. Хэсэгчлэн ба ганцаар суулгах сөөгний нүхийг 0.6 м диаметртэй, 0.5 м-ийн гүн ухаж бэлтгэж суулгана. Мод сөөгний үндэсний шороотой суулгах нүхний хэмжээ нь ухаж авсан мод, сөөгний шороотой хөрснөөс хамаардаг 0.9-1.9 м диаметртэй, 0.5-0.8 м гүн нүх ухаж бэлтгэнэ. Мод, сөөгийг суулгасны дараа гол анхаарах зүйл бол усалгаа, хөрс сийрүүлэх, нэмэлт бордоо, усалгаа, хэлбэржүүлэлтийг тогтмол хийх шаардлагатай юм.

Усалгаа: Мод, сөөгний усалгаа нь үндэсний систем тархсан орчимд чийгийн тохиромжтой нөхцөл бүрдүүлж, агаар болон дулааны горимыг зохицуулах зорилготой хийгдэнэ. Хавар агаарын харьцангуй чийгшилт багасч гандуу үе эхлэх 4-р сарын гурав дахь арав хоногоос эхлэн 5-р сард мод, сөөг ургамал тайван байдлаас өсөлт ургалтын эрчимтэй байдалд орж нахиалах, навч, шилмүүс, үүсэх, найлзуурын өсөлт эхлэх, улмаар цэцэглэх зэрэг үеүүд явагддаг тул ус чийг, шим тэжээлийн бодисын зарцуулалт нэмэгддэг тул усалгаа шийдвэрлэх ач холбогдолтой байна. Хавар, зуны улиралд тухайн жилийн хур тунадасны байдлыг харгалзан хөрсний чийгшилтийн хэмжээнээс хамаарч нэг модонд 30-40 л, сөөгт 20-30 л усаар тооцоолон эхний жилд 6-8 удаа, хоёр дахь жилд 3-5 удаа, гурав дахь жилд 2-4 удаа усалгаа хийнэ. Мод, сөөгний өсөлт зогсож нэг

настай найлзуур моджиж, навч, шилмүүсээ гөвж эхлэх 8-р сарын дунд буюу сүүлчээр усалгааг зогсоож, намар 9-р сарын сүүлчээр буюу 10-р сарын эхний арав хоногт хөрс хөлдөх хүртэл хугацаанд цэнэг усалгааг нэг модонд 50-60 л, сөөгт 30-40 л усаар тооцон услана.



Зураг 8. Мод тарих заавар

Бордолт: Мод, сөөгийг суулгасны дараа 3-4 жилээс эхлэн хөрсний үржил шимийг сайжруулах, шим тэжээлийн бодисын алдагдлыг нөхөх, ургамлын ургалт өсөлтийг эрчимжүүлэхэд шим, эрдэс бордоог хэрэглэнэ. Мод, сөөгийг шим, эрдэс бордоогоор бордох хугацаа нь үндэсний системийн эрчимтэй өсөлтийн үе шаттай тохирч байх шаардлагатай. Бууц, сангас нь эрдэс бордоотой харьцуулахад хөрсний үржил шим, бүтцийг сэргээж сайжруулах үйлчлэлээр илүү, элбэг олдох тул өргөн ашиглах хэрэгтэй. Эрдэс бордоог мод, сөөгний үндэсний системийн буюу ишний эрчимтэй өсөлтийн үе 5-р сарын хоёрдугаар 10 хоногоос 6, 7-р сарын хоёрдугаар 10 хоногт, 8-р сарын эхний арав хоногт хийх нь илүү тохиромжтой.

4.4 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 15. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (мян.₮)	Нийт зардал (мян.₮)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүй
Галын аюул, ослын үед авах арга хэмжээ	Утаа мэдрэгч бүхий галын дохиолол суурилуулах	Барилга	1	800.0	800.0	2026 он 10 сар	-Галын аюулгүй байдлын тухай хууль -Гамшгаас хамгаалах тухай хууль -ХАБЭА тухай хууль -Эрүүл мэндийн тухай хууль
	Гал унтраах хэрэгсэл байршуулах	Төслийн талбай	1	150.0	150.0	2026 он 9 сар	
	ХАБЭА сургалт	Ажилчид		100.0	500.0	2026 он 10 сар	
Анхны тусламж	Анхны тусламжийн иж бүрдэл ажлын байранд байрлуулах /Шаардлагатай нөхцөлд нөхөж байршуулах/	Төслийн талбай	1	100.0	500.0	2026 он 8 сар	
Цаг агаарын эрсдэл	Үйлдвэрийн ажлыг түр хугацаанд зогсоох	Төслийн талбай	Дотоод төлөвлөлтөөр			Шаардлагатай нөхцөлд	
Нийт				**1,950.0**			

4.5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 16. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Зардал /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ахуйн	Хог хаягдал түр хадгалах цэг байгуулах	Төслийн талбай	900.0		2026 он 10 сар	- Хог хаягдлын тухай хууль - Ариун цэврийн тухай хууль

	Төслийн үйл ажиллагаанаас гарах барилгын үеийн болон ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан ялгаж харьяа дүүрэгтэй гэрээ байгуулан тээвэрлүүлэх	Төслийн талбай	80.0	960.0	2026 он Сард 1 удаа	- Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, - Хог хаягдлыг ангилан ялгаж хаях журам
Халдваргүйжүүлэлт	Төслийн талбайн хог хаягдалд үнэрийн бохирдол үүсч болзошгүй тул ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийж байх	Төслийн талбайд	100.0	400.0	2026 он Улиралд 1 удаа	
	Төслийн талбайд септик систем эсвэл соруулдаг био нийтэд үйлчлэх ариун цэврийн өрөө, ариун цэврийн байгууламжтай байх	Дотоод төлөвлөлтөөр				
Нийт			**2,260.0**			

4.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 17. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Зардал /мян.төг/	Нийт зардал 5-н жилд (мян.төг)	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1. АГААРЫН ЧАНАР						
1.1	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	Төслийн талбайд 1 цэгт	Агаарын найрлага: жилд 4 удаа /2, 4, 8, 11 саруудад/	150.0	600.0	- MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага - MNS 3113:1981 Агаар мандал. Агаарын бохирдуулах бодисыг тодорхойлох аргад тавигдах ерөнхий шаардлага
2. УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ						

2.1	Усны ерөнхий шинжилгээ	Гүний худгийн уснаас	Жилд 1 удаа	150.0		- MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж - MNS 0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт - MNS 6561:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага
3. ХӨРСНИЙ БОХИРДОЛ						
3.1	Хөрсний хими физик шинж чанар, хүнд металлын шинжилгээг хийлгэх	Төсийн байрлал орчим, хог хаягдлын цэг	Жилд 2 удаа, 1 цэгт	200.0	400.0	- MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага - MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга - MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Нийт ОХШХ зардал				**1,150.0**		

4.7 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 18. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	**Урьдчилан тооцсон төсөв, мян.төг**	**Хэрэгжүүлэх хугацаа**			**Хариуцах албан тушаалтан**	**Тайлбар**
		2026 он				
		I	II	III		
1	2	3	4	5	6	7
Байгуллага дотооддоо мөрдөх байгаль орчны удирдлагын баримт бичгүүдийг боловсруулж, баталж дагаж мөрдөх						Химийн бодистой харьцах,хадгалах, устгах журам, Хог хаягдлын журам, Асгаралтын журам гэх мэт
Байгаль орчныг хамгаалах тухай	Үнийн саналаар					Ерөнхий үнэлгээний дүгнэлтийн онцгойлон анхаарах зүйлд заасны

хуулийн 10^1 зүйлийн дагуу байгаль орчны аудитыг хийлгэх /2 жил тутамд/	Дундажаар 4 сая					дагуу тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх.
Дүүрэг, хорооны удирдлага, ИТХ-тай хамтран ажиллах	Хамтран ажиллах гэрээний дагуу					
Экологийн паспорт хөтлөх	-	Дотоод төлөвлөлтөөр				Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн 31.3 заалт, “Байгаль орчны хамгаалал. Аж ахуй нэгжийн экологийн паспорт. Үндсэн дүрэм” MNS 4219:1994
Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал		Дотоод төлөвлөлтөөр				

4.8 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөл өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө

Хүснэгт 19. БОМТ-ий хэрэгжилтийг нөлөөлөл өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө

БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	**Тайлагнах хэлбэр**	**Мэдээл лийн агуулга**	**Хугацааны тов / он.сар/**	**Хариуцан зохион байгуулах албан тушаалтан**	**Зохион байгуулах газар**
1	2	3	4	6	7
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу БОУАӨЯ	Цахимаар /Eic.mn/	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянуулж, батлуулах	Жил бүрийн 12-р сарын 31-ны дотор	“Болор оргил юнион” ХХК	Цахимаар /Eic.mn/

		Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан хүргүүлж, хянуулах	Жил бүрийн 11-р сарын 01-ний дотор		
Нийслэлийн Байгаль орчны газар	Цахимаар /Eic.mn/ болон 1 хэвлэмэл хувь	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг дүгнүүлэх			БОМТ-ний биелэлтийг дүгнэх ажлыг хэсэг төслийн талбайд ажиллана.
Нөлөөллийн бүсийн оршин суугчид, Хан-Уул дүүргийн 21-р хороо, Засаг дарга болон холбогдох оролцогч талууд	Уулзалт, танилцуулга, санал хүсэлт авах хэлбэрээр	БОМТ-ний хэрэгжилт, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, хог хаягдлын менежмент, ОХШХ-ийн үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хүргэж, санал хүсэлт авах |	Жил бүрийн 11-р сарын 01-ний дотор		Төслийн талбай, Хан-Уул дүүргийн 21-р хороо, шаардлагатай тохиолдолд цахимаар

БҮЛЭГ 5. ХАВСРАЛТ

1. Хавсралт №1.Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ
2. Хавсралт №2. Газар ашиглах гэрчилгээ
3. Хавсралт №3. Газрын байршлын кадастрын зураг
4. Хавсралт №4. Богдхан уулын ДЦГ-ын хязгаарлалтын бүсэд газар ашиглах гэрээ
5. Хавсралт №5. Газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт
6. Хавсралт №6. Галын дүгнэлт
7. Хавсралт №7. Усны дүгнэлт